

## АРХИВЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН 2022 ОНЫ БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭ-ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

2022 оны 12 дугаар сарын 20

Улаанбаатар хот

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу Архивын ерөнхий газар (цаашид АЕГ гэх)-ын 2022 оны үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийв.

Хяналт-шинжилгээний хүрээнд “Алсын хараа 2050”, Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Хууль, тогтоомж, тогтоол, шийдвэрт тусгагдсан арга хэмжээний хэрэгжилт, Хууль зүй, дотоод хэргийн сайдын баталсан тушаал, шийдвэрт АЕГ-аас хариуцан хэрэгжүүлэхээр тусгагдсан болон тус байгууллагаас 2022 онд дэвшүүлсэн зорилт, үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлсэн байдал зэрэг үзүүлэлтээр тайлагнаж, үр дүнгийн өөрийн үнэлгээг хүргүүллээ.

Үнэлгээг бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн, байгууллагын чиг үүргийн үзүүлэлтийн, байгууллагын нээлттэй байдлын гэсэн гурван ерөнхий үзүүлэлтийн хүрээнд авч үзэж дүгнэсэн.

### **НЭГ. БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮР ДҮНГИЙН ҮНЭЛГЭЭ**

#### **1.1. “АЛСЫН ХАРАА-2050” МОНГОЛ УЛСЫН УРТ ХУГАЦААНЫ ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД 2021-2030 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХЭРЭГЖИЛТ**

1. Үндэсний санах ой архивын баримтын хадгалалт, хамгаалалтын нөхцөлийг сайжруулах чиглэлээр:

Говь-Алтай Аймгийн Төрийн архивын барилга 2022-2023 онд баригдахаар улсын төсөвт нийт 3.1 тэрбум төгрөг тусгагдаж, 2022 онд 1.550.0 сая төгрөгийн санхүүжилт батлагдсан. Барилга угсралтын ажлыг “Вентана констракшн” ХХК гүйцэтгэж, аймгийн Төрийн архивын барилга 75 хувийн гүйцэтгэлтэй байна.

Увс аймгийн Архивын тасгийн барилга 2022-2023 онд баригдахаар улсын төсөвт нийт 2.9 тэрбум төгрөг тусгагдаж, 2022 онд 1.450.0 сая төгрөгийн санхүүжилт батлагдсан. Барилга угсралтын ажлыг “Ундарга Петролиум” ХХК гүйцэтгэж, Төрийн архивын барилга 60 хувийн гүйцэтгэлтэй байна.

Увс аймгийн төрийн архивын барилга 2,856.5 сая төгрөгөөр, 2022 оны 12 дугаар сард, Говь-Алтай аймгийн төрийн архивын барилга 2,998.8 сая төгрөгөөр, 2023 оны 10 дугаар сард тус тус ашиглалтад оруулахаар гэрээ байгуулсан бөгөөд 2022 онд санхүүжихээр батлагдсан нийт 2,750.0 сая төгрөгийн санхүүжилтийг хянаж, ХЗДХЯ, Сангийн яаманд хүргүүлж, бүрэн олгосон. Барилгын ажлын гүйцэтгэлд зохиогчийн болон захиалагчийн хяналт ажлын гүйцэтгэл тухай бүрт хийгдэж холбогдох актыг үйлдэж тайланг гаргасан байна.

2. 2022 онд ОХУ-ын Шинжлэх ухааны архиваас олон улсын сансрын нислэгийн түүхэнд холбогдох 147 хуудас бүхий 87 баримтыг хуулбараар авсан.

Оросын Шинжлэх ухааны академийн Санктпетербургийн салбар архиваас Д.Г.Мессершмидтийн баримт бичгийн өв дэх толь зүйн материал: “Монгол, төвд толь бичгийн тойм” 458 хуудас зохиолыг цахимаар авч хэвлэн товч оршил бичиж, Үндэсний төв архивын сан хөмрөгт авсан.

БНСУ-ын Солонгос судлалын академи (The Academy of Korean Studies)-д хадгалагдаж байгаа XIII зууны Юань улсын хууль цаазын түүхэнд холбогдох “Чжичжэн-гийн хуулийн бичиг (Чжичжэнтяогэ) хэмээх хууль цаазын бичгийн дурсгалын тухай танилцуулгыг бичиж, АЕГ-ын 2022 оны 06 дугаар сарын 07-ны өдрийн 01/388 дугаартай албан бичгээр ХЗДХЯ-нд хүргүүлсэн.

“Алсын хараа 2050” урт хугацааны бодлогын баримт бичгийн үр дүнгийн үнэлгээг хүснэгтээр харуулбал:

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Заалтын тоо	Арга хэмжээний гүйцэтгэлийн хувь	Дундаж хувь	Дундаж оноо
			100		
1	7.4.18. Үндэсний санах ой архивын баримтын хадгалалт, хамгаалалтын нөхцөлийг сайжруулна.	1	100	100	
2	7.4.19.Монгол Улсын түүх, соёлд холбогдох гадаад улсад хадгалагдаж байгаа баримтыг нээн илрүүлж, худалдан авах ажлыг зохион байгуулах чиглэлээр:	1	100	100	
<b>Нийт</b>				<b>100</b>	<b>5</b>

-----oOo-----

### 1.3. ЗАСГИЙН ГАЗРЫН 2020-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ

Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.1.1-д Төрийн байгууллагын мэдээллийг иргэн, аж ахуйн нэгжээс шаарддаг байдлыг халж, иргэд нэг удаа бүртгүүлээд төрийн цахим үйлчилгээг шуурхай авдаг болох зорилтыг бүрэн хэрэгжүүлж, "Нэг иргэн-нэг бүртгэл" арга хэмжээг үргэлжлүүлэн, төрийн цахим үйлчилгээг нэгдсэн стандартад оруулна, 4.2.1-д Төрийн бүх шатанд байгаа авлигыг таслан зогсоох, урьдчилан сэргийлэх хөтөлбөр хэрэгжүүлж, авлигын гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг нэмэгдүүлж, төр иргэдийн мэдээлэл солилцох тогтолцоог боловсронгуй болгоно, 4.2.5-д Төрийн албан хаагчийн үйл ажиллагааг үнэлэхдээ ажлын гүйцэтгэл, үйлчлүүлэгчийн үнэлгээ, ёс зүй, сахилга хариуцлагыг шалгуур болгож, ёс зүйн зөрчил гаргасан төрийн алба хаагчид хүлээлгэх хариуцлагыг чангатгана, 4.3.8-д Монгол Улсын түүх соёлд холбогдох гадаад улсад хадгалагдаж байгаа баримтыг эх нутагт нь байршуулж, үндэсний санах ой болох архивын баримтын хадгалалт, хамгаалалтын нөхцөлийг сайжруулж, архивын баримтыг эдийн засгийн эргэлтэд оруулна гэсэн зорилтууд тусгагдсан. Уг хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний нарийвчилсан төлөвлөгөөнд 2022 онд АЕГ-аас хариуцан хэрэгжүүлэхээр 7 арга хэмжээ тусгагдсан.

Эдгээр арга хэмжээг дараах байдлаар хэрэгжүүлэн ажилласан байна. Үүнд:

1. "АЕГ-ын цогцолбор барилгын тоног төхөөрөмж, техник хэрэгслийн хангалт" төслийн зөвлөх байгууллагатай хамтран ажиллах ажлын хэсгийг АЕГ-ын даргын А/19 дугаар тушаалаар батлуулж, төслийн зөвлөх үйлчилгээ үзүүлэх "БНСУ-ын Ди Би Консорциум"-тай хамтран ажиллах гэрээнд 2022 оны 03 дугаар сарын 25-ны өдөр гарын үсэг зурсан. Төслийн зөвлөх үйлчилгээ үзүүлэх БНСУ-ын "Ди Би Консорциум"-ын албан хаагчид АЕГ-ын өнөөгийн нөхцөл байдал, салбарын чиг хандлагын талаар судалгааг (Site survey) хийж, Basic Design Report боловсруулсан. Төслийн зөвлөх үйлчилгээ үзүүлэх БНСУ-ын "Ди Би Консорциум"-аас ирүүлсэн тендерийн баримт бичгийг 2022 оны 09 дүгээр сарын 13-ны өдрийн 01/602 дугаартай албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн.

2. "Цахим архив, албан хэрэг хөтлөлтийн талаар баримтлах чиглэл" боловсруулж, Архивын ерөнхий газрын 2022.11.10-ны өдрийн 01/842 дугаартай албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн. Төрийн 37 архивт хадгалагдаж буй цаасан болон тусгай суурьтай баримтаас 2022 онд 727 хөмрөгийн 1,106 дансны 21,377 хадгаламжийн нэгжийн 1,260,542 хуудас баримтыг цахим хэлбэрт шилжүүлж, үүссэн мэдээллийн сангаас архивын лавлагаа, мэдээллийг иргэн, хуулийн этгээдэд шуурхай олгож байна.

3. Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг 2022 оны 03 дугаар сарын 02-ны өдөр батлуулж, хэрэгжилтийг хангуулж, 2022 оны 06 дугаар сард тайлагнасан. Төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний удирдах албан тушаалын 43 албан хаагчийн хөрөнгө орлогын мэдүүлгийг гаргуулж, хуулийн хугацаанд баталгаажуулсан. Нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн 11 этгээдийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг гаргуулж, Авлигатай тэмцэх газраар хянуулсан. Авлигатай тэмцэх газраас ирүүлсэн дүгнэлтийг олон нийтэд ил тод мэдээлсэн. Архивын ерөнхий газраас байгуулсан гэрээ болон хяналт, шалгалтын хийх ажлын хүрээнд ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх мэдэгдэл давхардсан байдлаар 98 албан хаагчаас гаргуулж, байгууллагын шилэн данс болон АТГ-ын [meduuleg.iaas.mn](http://meduuleg.iaas.mn) хуудсанд бүртгэж, байршуулсан. Тайлант хугацаанд авлига, ашиг сонирхлын зөрчил илрээгүй болно.

4. Засгийн газрын 2019 оны 33 дугаар тогтоолоор батлагдсан Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрмийг байгууллагын нийт албан хаагчид хэрэгжүүлэн ажиллаж байна. Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2022 оны А/105 дугаар тушаалаар баталсан "Салбарын албан хаагчдын ёс зүйн үлгэрчилсэн загвар"-ыг Архивын ерөнхий газрын нийт албан хаагчдад 2022 оны 05 дугаар сарын 04-ны өдөр танилцуулсан.

Архивын ерөнхий газрын 2022 оны А/83 дугаар тушаалаар Архивын ерөнхий газрын "Ёс зүйн зөвлөлийн бүрэлдэхүүн"-ийг 7 гишүүнтэйгээр шинэчлэн баталж, дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулсан.

Байгууллагын соёл, хамт олны сэтгэл зүйн уур амьсгал", "Хүмүүн байхын учир ёс суртахуунд нь оршвой", "Мэргэжлийн ёс зүйн асуудлууд" сэдэвт сургалтыг тус тус зохион байгуулж, 270 албан хаагч хамрагдсан. Тайлант хугацаанд ёс зүйн зөрчил гаргасан тухай гомдол, санал ирээгүй.

5. Говь-Алтай Аймгийн Төрийн архивын барилга 2022-2023 онд баригдахаар улсын төсөвт нийт 3.1 тэрбум төгрөг тусгагдаж, 2022 онд 1.550.0 сая төгрөгийн санхүүжилт батлагдсан. Барилга угсралтын ажлыг "Вентана констракшн" ХХК гүйцэтгэж байна. Говь-Алтай Аймгийн Төрийн архивын барилга 75 хувийн гүйцэтгэлтэй байна.

Увс аймгийн Архивын тасгийн барилга 2022-2023 онд баригдахаар улсын төсөвт нийт 2.9 тэрбум төгрөг тусгагдаж, 2022 онд 1.450.0 сая төгрөгийн санхүүжилт батлагдсан. Барилга угсралтын ажлыг "Ундарга Петролиум" ХХК гүйцэтгэж байна. Увс аймаг Улаангом сум дахь Архивын барилга 60 хувийн гүйцэтгэлтэй байна.

Увс аймгийн төрийн архивын барилга 2,856.5 сая төгрөгөөр, 2022 оны 12 дугаар сард, Говь-Алтай аймгийн төрийн архивын барилга 2,998.8 сая төгрөгөөр, 2023 оны 10 дугаар сард тус тус ашиглалтад оруулахаар гэрээ байгуулсан бөгөөд 2022 онд санхүүжихээр батлагдсан нийт 2,750.0 сая төгрөгийн санхүүжилтийг хянаж ХЗДХЯ, Сангийн яаманд хүргүүлж, бүрэн олгосон. Барилгын ажлын гүйцэтгэлд зохиогчийн болон захиалагчийн хяналт ажлын гүйцэтгэл тухай бүрт хийгдэж холбогдох актыг үйлдэж тайланг гаргасан байна.

6.2022 онд ОХУ-ын Шинжлэх ухааны архиваас олон улсын сансрын нислэгийн түүхэнд холбогдох 147 хуудас бүхий 87 баримтыг хуулбараар авсан. Оросын Шинжлэх ухааны академийн Санктпетербургийн салбар архиваас Д.Г.Мессершмидтийн баримт бичгийн өв дэх толь зүйн материал: "Монгол, төвд толь бичгийн тойм" 458 хуудас зохиолыг цахимаар авч хэвлэн товч оршил бичиж, Үндэсний төв архивын сан хөмрөгт авсан.

Архивын ерөнхий газрын дарга С.Энхбаатар, Хууль зүй, дотоод хэргийн сайдын зөвлөх, Академич С.Нарангэрэл, Шинжлэх ухааны академийн Түүх угсаатны зүйн хүрээлэнгийн Ойрхи үеийн түүхийн салбарын эрхлэгч, доктор (Ph.D) Ч.Батдорж нарын бүрэлдэхүүнтэй баг 2022 оны 06 сарын 17-ноос 24-ний өдрүүдэд ОХУ-д албан томилолтоор ажилласан. Үүний үр дүнд 1915 оны хүн амын тооллогын холбоотой баримтууд болон цаашид ямар баримтууд байгааг илрүүлэн судлах, судлаач илгээж ажиллуулах зэрэг ажлыг хамтран хэрэгжүүлэх зорилгоор хамтын ажиллагааны санамж бичгийг байгуулахаар тохиролцсон.

БНСУ-ын Солонгос судлалын академид хадгалагдаж байгаа XIII зууны Юань улсын хууль цаазын түүхэнд холбогдох "Чжичжэн-гийн хуулийн бичиг хэмээх хууль цаазын бичгийн дурсгалын тухай танилцуулгыг бичиж, ХЗДХЯ-нд хүргүүлсэн.

7.2022 онд Аман өв төслийн хүрээнд 150 гаруй хөдөлмөрийн баатрын судалгааг гаргаж, 14 хөдөлмөрийн баатрын дурсамж яриаг 38 цагийн 1242 gb дүрс бичлэг, 159ш гэрэл зургаар Үндэсний төв архивын сан хөмрөгийг баяжуулсан.

Монгол Улсын төрийн зүтгэлтэн, Ерөнхий сайд асан Д.Содном, Ардын уран зохиолч П.Бадарч нарыг "Монголын баримтат аман өв" төсөлд оролцуулсан.

**Дүгнэлт:** Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, арга хэмжээний хүрээнд "АЕГ-ын цогцолбор барилгын тоног төхөөрөмж, техник хэрэгслийн хангалт төсөл"-ийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд тайланг холбогдох байгууллагад хүргүүлсэн, "Цахим архив, албан хэрэг хөтлөлтийн хөтөлбөр"-ийн төслийг боловсруулж, Хууль зүй дотоод хэргийн яаманд хүргүүлсэн, төрийн зарим архивын зориулалтын байрны төсвийн асуудлыг

шийдвэрлүүлсэн, Монгол улсын түүх соёлд холбогдох гадаад улсын архивт буй баримтыг илрүүлж, үндэсний сан хөмрөгөө баяжуулсан зэрэг арга хэмжээг хэрэгжүүлж ажиллажээ.

Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилт 100% хувийн биелэлттэй, “үр дүнтэй” гэж дүгнэж байна.

Хэрэгжилтийн үр дүнгийн үнэлгээг хүснэгтээр харуулбал:

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний гүйцэтгэлийн хувь		Дундаж хувь	Дундаж оноо
		70	100		
1	7	-	7	100%	5.0

-----oO-----

#### 1.4. ЦАХИМЖУУЛАЛТЫН АЖЛЫН ХЭРЭГЖИЛТ

1.4.1. Монгол улсын Их хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа 2050” Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний 5.3.11-д “Төрийн байгууллагаас авдаг тодорхойлолт, зөвшөөрөл, лавлагаа, дүгнэлтийг цахим хэлбэрт бүрэн шилжүүлэх...” 5.3.16-д “Төрийн байгууллагын албан хэрэг хөтлөлт, албан бичгийн солилцооны үйл ажиллагааг цахим хэлбэрт бүрэн шилжүүлж, сүлжээ бий болгох”, 7.4.18-д “Үндэсний санах ой архивын баримтын хадгалалт, хамгаалалтын нөхцөлийг сайжруулах зорилтууд тусгагдсан.

Архивын салбарт “Цахим архив, албан хэрэг хөтлөлтийн талаар баримтлах чиглэл” батлах тухай Хууль зүй, дотоод хэргийн сайдын тушаалаар батлуулахаар төслийг боловсруулж, Хууль зүй, дотоод хэргийн яаманд 2022 оны 11 дүгээр сарын 10-ний өдрийн 01/842 дугаартай албан бичгээр хүргүүлсэн.

Төрийн архивууд 747 хөмрөгийн 1148 дансны 29283 хадгаламжийн нэгжийн 1738881 хуудас баримт сканердаж, мөн 700 хөмрөгийн 1219 дансны 30735 хадгаламжийн нэгжийн 1258070 хуудас баримтыг цахимжуулсан.

Төрийн архивын нэгдсэн [www.e-document.gov.mn](http://www.e-document.gov.mn) системд 21 аймгийн төрийн архивт хөмрөг үүсгэгч 4263 хөмрөгийн, 8016 дансны 494457 хадгаламжийн нэгжийн бүртгэлийн 6821082 баримтын бүртгэлийг хөрвүүлж, 14045GB цахим файл, 3184174 газар зүйн нэр, 2872953 багйууллагын нэр, 36931083 хүний нэрийг холбож оруулсан.

**Дүгнэлт:** Архивын салбарт “Цахим архив, албан хэрэг хөтлөлтийн талаар баримтлах чиглэл” батлах тухай Хууль зүй, дотоод хэргийн сайдын тушаалаар батлуулахаар төслийг боловсруулж, Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлээд байна.

Иймд цахимжуулалтын ажил 100 хувийн биелэлттэй, “үр дүнтэй гэж дүгнэж байна.

-----oO-----

## 1.5. ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ХӨГЖЛИЙН ҮЗҮҮЛЭЛТИЙН ҮНЭЛГЭЭ

АЕГ-ын 2022 оны эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийг архивын сан хөмрөгийн нөхөн бүрдүүлэлт, баримтад нягтлан шалгалт, дахин боловсруулалт хийсэн тоо хэмжээ, архиваас олгосон лавлагаа, хуулбар, мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэлт гэсэн чиглэлээр авч үзлээ. Үүнд:

а/ 2022 онд шинээр ашиглалтад хүлээн авсан 761 объектын 6842 хавтаст хэрэг зураг төсөл, техникийн баримт бичиг болон хөмрөг үүсгэгч 39 байгууллагын 15680 хадгаламжийн нэгж, мөн 5 байгууллага, 6 хүний тусгай төрлийн баримт буюу 49 дүрс бичлэг, 2 цомог 4515 хн /ширхэг/ гэрэл зураг, цаасан суурьтай, 613 хадгаламжийн нэгжээр Үндэсний архивын сан хөмрөгийг баяжуулсан.

б/ Үндэсний төв архивт 11165 хадгаламжийн нэгж, зураг төслийн 5950 хадгаламжийн нэгжид нягтлан шалгалт, дахин боловсруулалт хийж, УТА-ын дэргэдэх БНШАЗК-ын 2022 оны 02, 03, 04, 05, 07 дугаар хурлаар хэлэлцүүлж батлуулсан.


в/ Тайлангийн хугацаанд 3156 байгууллага, 27437 иргэний 41052 лавлагаа, 118,121 хуулбар олгосон байна. Тусгай төрлийн 1407.5 минутын дүрс бичлэг, 1720 ширхэг гэрэл зураг олгосон. Энэ үзүүлэлт нь өмнөх оноос 8800 лавлагаагаар өссөн, 12440 хуулбараар өссөн үзүүлэлттэй байна. Мөн өмнөх онд 25168 иргэд, байгууллага үйлчлүүлж байсан бол 2022 онд 30593 болж архиваас үйлчилгээ авч буй үйлчлүүлэгчийн тоо жил бүр нэмэгдэж, олгож буй лавлагааны тоо өсч байгаа нь харагдаж байна.

Онлайнаар 4812 иргэний хүсэлтийг хүлээн авч, 6061 архивын лавлагааг олгож шийдвэрлэсэн.

Архивын ерөнхий газрын “1800-1205” Архивын лавлах утсаар нийт 7699 иргэн, байгууллагад архивын мэдээлэл өгсөн.

Тайлангийн хугацаанд иргэд байгууллагад үзүүлсэн үйлчилгээний тоо, гаргасан лавлагаа, хуулбарын тоог графикаар харуулбал:

График-1



г/ Үндэсний төв архивын баримтаас 23809 хадгаламжийн нэгжийн 347020 хуудас баримтыг цахим хэлбэрт шилжүүлсэн байна. Мөн Монгол улсын хүн амын тооллогын баримтаас 519730 (11 сарын байдлаар) хүний мэдээллийг цахим санд бүртгэж, тулгаж баталгаажуулсан байна.

График-2



Төрийн архивууд 747 хөмрөгийн 1,148 дансны 29,283 хадгаламжийн нэгжийн 1,738,881 хуудас баримт сканердаж, мөн 700 хөмрөгийн 1,219 дансны 30,735 хадгаламжийн нэгжийн 1,258,070 хуудас баримтыг цахимжуулсан.

**АРХИВЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД  
ХИЙСЭН ҮНЭЛГЭЭНИЙ НЭГДСЭН ДҮН**  
(2022 оны үйл ажиллагааны үр дүн)

Үзүүлэлт		Үр дүнгийн үнэлгээ	
		Хувь	Оноо
Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн үнэлгээ	Хууль, тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт	100	5
	Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт	100	
	“Алсын хараа 2050” Монголд улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хэрэгжилт	100	
	УИХ, Засгийн газраас баталсан үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт	100	
	Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн үнэлгээ	100	
Байгууллагын чиг үүргийн үзүүлэлтийн үнэлгээ	Байгууллагын тухайн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт	98.5	
	Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн биелэлт	100	
Байгууллагын нээлттэй байдлын үнэлгээ	Байгууллагын ил тод байдлын үнэлгээ	100	
	Шилэн дансны хөтлөлтийн үнэлгээ	99	
	Байгууллагын шударга байдлын түвшний үнэлгээ	-	
	Хэрэглэгчийн үнэлгээ	96	
<b>Ерөнхий үнэлгээ</b>		<b>99.3</b>	